



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/334

Мандалговь

Гамшгийн эрсдэлийг бууруулах
бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс шаардлагатай мэдээ мэдээллийг тогтмол солилцож, онцгой байдлын байгууллагын харилцан ажиллагааг сайжруулан иргэдэд сэрэмжлүүлэг мэдээг шуурхай хүргэж ажиллахыг Онцгой байдлын газар /хурандаа М.Адъяабаатар/, Ус цаг уур, орчны шинжилгээний төв /Э.Азжаргал/ нарт даалгасугай.

2. Тус аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ, аяны хэрэгжилтийг хангуулах, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, нөлөөллийн ажил, арга хэмжээг зохион байгуулахыг Онцгой байдлын газар /хурандаа М.Адъяабаатар/-т үүрэг болгосугай.

3. Аяны хүрээнд шаардагдах зардал 1.840.000 (Нэг сая найман зуун дөчин мянга) - н төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Л.Доржбат/, нягтлан бодогч /Н.Энхмарт/ нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /хурандаа М.Адъяабаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.АНХБАЯР



4822111147